

Маргааны товч

Улсын байцаагчийн 2022.11.02-ны 6572 тоот дүгнэлтээр “Монголын үндэсний их сургууль” ХХК-д сургалтын ажил эрхлэх тусгай зөвшөөрлийг 2013.12.26-ны өдөр бүртгэсэн бүртгэлийг илт хууль бус захиргааны актад тооцож, “Монголын үндэсний их сургууль” ХХК-ийн 2013.12.26-ны хуулийн этгээдийн улсын бүртгэсэн бүртгэлийг, “Монголын үндэсний их сургууль” НҮТББ-аар бүртгэсэн 2015.03.11-ний өдрийн бүртгэлийг тус тус хүчингүй болгосон.

Нэхэмжлэгчээс: “... манай сургууль холбогдох яамнаас авсан тусгай зөвшөөрлийн дагуу үйл ажиллагаа явуулж байсан, сургуулийн ангилал өөрчилсөн тушаал хүчингүй болсон байхад уг тушаалыг үндэслэн гаргасан улсын байцаагчийн дүгнэлт үндэслэлгүй, сонсох мэдэгдэх ажиллагааг хууль журмын дагуу явуулаагүй, хариуцагч нь улсын бүртгэлтэй холбоотой баримтуудад дүгнэлт хийх ёстой атал өөрт хамааралгүй хөндлөнгийн баримтуудад дүгнэлт хийсэн нь хууль бус ...” гэж,

Хариуцагчаас “...Бодит байдал “Монголын үндэсний их сургууль” нэртэй сургууль нь дээд боловсролын сургалтын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй эсэх нь тодорхойгүй аль хуулийн этгээд нь уг үйл ажиллагаа явуулах нь тодорхойгүй, ойлгомжгүй, Монголын үндэсний дээд сургууль нь улсын бүртгэлийн бүртгэлд ****118 гэсэн регистрийн дугаартайгаар бүртгэгдсэн бол “Монголын үндэсний их сургууль” ХХК нь ****615 гэсэн регистрийн дугаараар бүртгэгдсэн байх бөгөөд 2 өөр бие даасан зорилго, үйл ажиллагаа бүхий хуулийн этгээдүүд юм ...”

Гуравдагч этгээд Монгол Улсын Их сургуулиас “... сайдын тушаалаар Монголын Үндэсний дээд сургуулийг “их сургууль”-ийн ангилалд хамааруулснаас бус оноосон нэрийг нь огт өөрчлөөгүй, 2013 онд үүсгэн байгуулсан “Монголын үндэсний их сургууль” ХХК-д боловсрол, сургалтын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох тушаал гараагүй, маргаан бүхий дүгнэлтээр холбогдох тусгай зөвшөөрлийг авсны дараа улсын бүртгэлд бүртгүүлэхээр шийдвэрлэсэн нь нэхэмжлэгчийн эрх хууль ёсны ашиг сонирхлыг зөрчөөгүй ...” гэж тус тус маргасан.